

**АРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ 01 ДҮГЭЭР
САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны мэдээлэл

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 5 дугаар хуралдаан 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр 79.4 хувийн ирцтэйгээр хуралдаж Хурлын зөвлөл байгуулах тухай асуудлуудыг хэлэлцэн батлах тухай, Хорооны ажиллах журмыг шинэчлэн батлах тухай, Төлөөлөгчийн ёс зүйн дүрэм батлах тухай, Төлөөлөгчийн энгэрийн тэмдэг, үнэмлэх, албан бичгийн хэвлэмэл хуудасны загвар, хэрэглэх үлгэрчилсэн журам батлах тухай, Аймгийн ИТХ-ын ажлын албаны бүтэц, орон тоог батлах тухай, Орон нутгийн сангийн журам батлах тухай, □"Архангайн орон сууцны корпораци" орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулж, дүрэм батлах тухай, Архангай орон сууцны корпорацийн "Орон сууц түрээслэн өмчлүүлэх журам" батлах тухай, □□"Ар ус ундарга" ХХК-ийн дүрмийг баталж, ТУЗ-ийг томилох тухай, Газрын үнэлгээний бүсчлэл, газрын төлбөрийн хувь хэмжээг шинэчлэн тогтоох тухай, Барилга шилжүүлэх тухай зэрэг 11 асуудлыг хэлэлцэн баталлаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл

Монгол Улс хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн иргэн төвтэй төр улсыг шинэ Үндсэн хуулиараа тунхагласны түүхт 30 жилийн ой 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр аймгийн удирдлагууд, төрийн албан хаагчид Монгол Улсын Өрлөг жанжин Гэлэгдоржийн Дэмидийн хөшөөнд цэцэг өргөж хүндэтгэл үзүүлж, олон нийтэд чиглэсэн үндэсний бөхийн барилдаан, эссэ бичлэгийн уралдаан зэрэг бусад арга хэмжээг зохион байгууллаа.

2021 онд аймгийн Онцгой комисс 22 удаа хуралдаж цаг үеийн асуудлыг шийдвэрлэж, Коронавируст халвар /КОВИД-19/-ын цар тахлын аюулаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авч гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт 5 удаа 63 хоног, гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт 4 удаа 302 хоног тус тус шилжин ажиллаж, нийт 13000 гаруй төрийн алба хаагч, 2000 гаруй техник хэрэгсэлтэйгээр үүрэг гүйцэтгэсэн байна.

2021 онд гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 117.4 сая төгрөг, гамшгаас хамгаалах арга хэмжээнээс 683.5 сая төгрөг, хөтөлбөр арга хэмжээнээс 162.6 сая төгрөг, Засгийн газраас 50.0 сая төгрөг, хандив тусламжийн 59.0 сая төгрөг, нийт 1072.5 сая төгрөгийг зарцуулсан.

2022 онд аймгийн Онцгой комисс цаг үеийн асуудлаар 2 удаа хуралдаж ,2021 онд аймгийн хэмжээнд гарсан гамшиг осол, онцгой комиссоос хэрэгжүүлсэн ажил, аймгийн хэмжээнд малын гоц халдварт шүлхий өвчний нөхцөл байдал хэрэгжүүлэх арга хэмжээ, 2021 онд коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахалтай тэмцэх талаар хийсэн ажил, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцэж, 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн аймгийн хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын "Улбар шар түвшин" (халдвар голомтот тархалттай)-д шилжүүлэхээр шийдвэрлэж, "Улбар шар түвшин"-д шилжүүлсэнтэй холбогдуулан тодорхой төрлийн арга хэмжээ авч ажиллахыг холбогдох мэргэжлийн байгууллага болон аж ахуйн нэгж байгууллагуудад үүрэг болгосон.

Аймгийн Онцгой комиссын Шуурхай штаб 24 цагаар тогтмол ажиллаж байгаа бөгөөд 2022 онд 1 удаа хуралдаж аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон тогтолцооны удирлагын багуудын үйл ажиллагааг идэвхижүүлэн, сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нарыг цахимаар оролцуулан үүрэг даалгавар өгсөн.

2022 оны 01 дүгээр сард 20 удаагийн аюулт үзэгдэл осол, тохиолдсоны дотор объектын гал түймэр 2, газар хөдлөлт 2, малын гоц халдварт өвчин 13, эрэн хайх аврах ажиллагааны дуудлага 2, хүний гоц халдварт өвчин коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын 1 дуудлага тус тус хүлээн авч ажилласан.

2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр аймгийн удирдах ажилтны ээлжит шуурхай зөвлөгөөн, сумдын Засаг дарга нартай цахим хурал, 01 дүгээр 27-ны өдөр сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нартай цахим хурлыг тус тус зохион байгуулж, аймгийн удирдлагуудаас байгууллага, сумдын дарга нарт цаг үеийн ажилтай холбоотой үүрэг даалгавруудыг өгсөн.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны А/143 дугаар захирамжаар батлагдсан журмын дагуу аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 26 агентлаг, 19 сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж байна.

Засгийн газрын гишүүний аймгийн Засаг даргатай 2022 онд байгуулах хамтран ажиллах гэрээнд тусгах саналыг байгууллагуудаас нэгтгэн авч холбогдох яамдад хүргүүлсэн.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулт, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Архангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Эдийн засгийн хөгжлийн яаманд хүргүүлсэн.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн хөгжлийн 2022 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдэж байна.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд Татвар төлөлт

2022 оны 01 дүгээр сард хүлээгдэж буй гүйцэтгэлээр улсын төсөвт 314.6 сая төгрөг төвлөрүүлэхээс 314.6 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 100 хувиар, орон нутгийн төсөвт 1113.3 сая төгрөг төвлөрүүлэхээс 1113.3 сая төгрөг төвлөрүүлэн төлөвлөгөөг 100 хувиар тус тус биелүүллээ.

Хөрөнгө оруулалт

2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 87922.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 60 төсөл арга хэмжээ, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3615.0 сая төгрөгийн 22 төсөл, арга хэмжээ тус тус хэрэгжихээр батлагдаж, худалдан авах ажиллагааны бэлтгэл ажил хийгдэж байна.

Санхүүгийн хяналт

МУБИС-ийн Архангай аймаг дахь Багшийн сургуульд төлөвлөгөөт хяналт шалгалт, орон нутгийн өмчийн байгууллагуудад гүйцэтгэлийн хяналт хийгдэж эхэлсэн. Нөхөн төлбөрийн барагдуулалтын чиглэлээр дотоод хяналт хийгдэж байна.

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд

Хууль, хяналт

2022 оны 01 дүгээр сард 20 удаагийн аюулт үзэгдэл осол, тохиолдсоны дотор объектын гал түймэр 2, газар хөдлөлт 2, малын гоц халдварт өвчин 13, эрэн хайх аврах ажиллагааны дуудлага 2, хүний гоц халдварт өвчин коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын 1 дуудлага тус тус хүлээн авч ажилласан.

Цаг агаарын аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх анхааруулах 3 мэдээг ОБЕГ-ын ГШУГ-аас хүлээн авч орон нутгийн УЦУАлбанаас тодотгож 19 сумын Засаг дарга, Тамгын газрын дарга, цаг уурчид нийт 6552 алба хаагчдад багц мессежээр болон Хаан банкны онлайн сүлжээгээр дамжуулж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллах үүрэг чиглэл өгч, орон нутгийн “АВ”, “Тамир”, телевизээр сэрэмжлүүлгийг урсдаг зар хэлбэрээр өдөрт 4 удаа, 6 удаагийн давтамжтай нийт 320 удаа иргэдэд нэвтрүүлж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллаа.

Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу аймгийн хэмжээнд Шуурхай штабыг идэвхжүүлэн ковид-19 халдвар болон малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх мэргэжил аргагүй, сумдыг удирдлагаар ханган ажиллаж байна.

Монгол Улсын Шадар сайдын баталсан удирдамжийн дагуу худалдаа, үзвэр үйлчилгээний газруудын барилга байгууламжид Гамшгаас хамгаалах болон Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, стандарт, норм нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгуулж байна.

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, цаг үеийн мэдээ мэдээлэл, заавар зөвлөмж, мэдээг өдөрт 2-4 удаагийн давтамжтайгаар олон нийтэд мэдээлж Онцгой байдлын газрын пэйж хуудсанд дээрх мэдээ сурвалжлагыг байрлуулж 6520 иргэнд хүрч хандалт авсан байна.

2021 онд аймгийн хэмжээнд 412 гэмт хэрэг бүртгэгдсэнээс хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 124, хулгайлах гэмт хэрэг 129, иргэдийн өмчийн хулгайн гэмт хэрэг 44, малын хулгайн гэмт хэрэг 65, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгсэл ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 26, согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 106, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 31, гэмт хэргийн улмаас нас барсан иргэн 22, гэмт хэргийн илрүүлэлт 57.5 хувьтай байна.

Нийт 19445 захиргааны зөрчил бүртгэгдсэнээс Зөрчлийн тухай хуулийн дагуу 18480 иргэнд 746.0 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ 1351.0 сая төгрөг, нөхөн төлүүлэлт 56.3 хувьтай байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газар 2022 оны 01 дүгээр сард ХУН системд 4308 объектыг эрсдэлийн үнэлгээнд хамруулж, хүнсний чиглэлийн худалдаа үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийг 267 иргэнийг igov.mn портал сайтад бүртгэсэн байна.

Мэргэжлийн хяналтын газрын лабораторид 71 сорьц 258 үзүүлэлтээр сорилт шинжилгээг хийснээс 6 үзүүлэлт шаардлага хангаагүй байна.

Стандарт, хэмжил зүйн хэлтэс таван сумын 4 аж ахуй нэгж, байгууллага, 16 иргэнээс ирүүлсэн тохирлын гэрчилгээ сунгуулах хүсэлтийг хүлээн авч, баталгаажуулалтын хурлаар хэлэлцэн шийдвэрлэж гэрчилгээ олгосон байна.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд

Боловсрол

“Монгол Улс дахь тогтвортой хөгжлийн зорилт-4”-ийн хэрэгжилтийн ахиц дэвшлийн үнэлгээний тайлан төслийн хэлэлцүүлгийг БШУЯ, ЮНЕСКО олон улсын байгууллагатай 2022 оны 1 дүгээр сарын 21-нийн өдөр зохион байгуулж, хэлэлцүүлэгт боловсролын салбарын бүх түвшний байгууллагын төлөөлөл, аймаг, нийслэлийн Боловсролын газрын албан хаагчдын төлөөлөл оролцлоо.

“Хүүхэд хөгжил Архангай” арга хэмжээний хүрээнд Архангай аймгийн математикийн багш нарт 80 цагийн сургалтыг зохион байгууллаа. Сургалтад Монгол Улсын гавъяат багш В.Адъяасүрэн, Б.Санчир болон Архангай аймгийн 25 багш оролцож, багш нарт батламж гардууллаа.

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтээс багш нар “Онлайн флатформыг ашиглан цахимаар хичээл, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах” сэдвээр сургалтыг 1 дүгээр сарын 10-12-ны өдрүүдэд цахимаар зохион байгуулж багш, төрийн албан хаагч нар хамрагдлаа.

Соёл урлаг

Аймгийн Нийтийн номын сан коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед уншлагын танхимын 50 хувийн дүүргэлттэй халдвар, хамгааллын дэглэмийг мөрдөн танхимын үйлчилгээ хүргэн ажиллаж байна.

Нийтийн уншлагын танхимаар 22 уншигч шинээр бүртгэж, 339 ирэгсэдэд 98 ном, 215 сонин сэтгүүл, хүүхдийн уншлагын танхимаар 23 уншигч шинээр бүртгэж, 366 ирэгсэдэд 606 ном, гэрээр ном олголтоор 50 ирэгсэдэд 150 номоор тус тус үйлчилсэн байна.

Аймгийн Музей соёлын өв, үнэт зүйлийг бүртгэн баримтжуулах, хадгалж хамгаалах, нийтийн хүртээл болгох зорилгоор “Архангайн бүртгэл мэдээллийн сан” пэйж хуудсыг ажиллуулан “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл”, “Соёлын биет өв”

түүний талаархи мэдээллийг олон нийтэд хүргэн соёлын өвийн ойлголтыг нийтэд сурталчилан таниулж байна.

Эрүүл мэнд

Эрүүл мэндийн байгууллагуудын хамгаалах хувцас хэрэгслийн нөөцийн үнэлгээ хийж, шаардлага нөөцийн тооцоолол судалгаа хүсэлтийг Аймгийн Онцгой комисст уламжилсан. Мөн эрүүл мэндийн байгууллагуудад 1 сарын нөөц бүрдүүлж ажиллахыг үүрэг болгосон.

“Томуу, томуу төст өвчин, сэргийлэлт, эмнэлзүй, эмчилгээний удирдамж” цахим сургалтыг ЭХЭМҮТ-тэй хамтран зохион байгуулж, бүх, сум өрхийн эрүүл мэндийн төвүүдийн нийт 46 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж мэдлэгээ дээшлүүлсэн.

Архангай аймагт 2021 онд батлагдсан коронавирүст халдварын нөхцөлд байдалд хийсэн судалгааны дүгнэлт, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны санал, зөвлөмжийг аймгийн Онцгой комисст танилцуулсан.

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 01 тоот албан даалгаврын дагуу Нэгдсэн эмнэлэгт ковидын амбулаторийг байгуулж, нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, рентген оношилгоонд халдварын батлагдсан тохиолдол болон сэжигтэй тохиолдлуудыг хамруулж байна.

PCR шинжилгээнд 2942 хүнийг хамруулж, түргэвчилсэн шинжилгээнд 1623 хүнийг хамруулж, 1419 батлагдсан тохиолдлыг илрүүлж, тусгаарлан эмчилгээнд хамруулсан.

Батлагдсан тохиолдлуудын тандалт судалгааг хийж, 2561 хавьтлыг тогтоож, хянасан. Вакцинжуулалтын 23 цэгт коронавирүсийн эсрэг вакцинжуулалтын 1 дүгээр тунд 36, 2 дугаар тунд 86, 3 дугаар тунд 1171, 4-р тунд 800 хүнийг хамруулсан.

Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй 2 удаа цахим хурал хийж, коронавирүст халдварын омикрон хувилбарын тархалтын үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдал, тандалт судалгаа, коронавирүст халдварын эсрэг дархлаа сэргээх нэмэлт 3, 4 дүгээр тунд зорилтот бүлгийн иргэдийг хамруулах чиглэлээр мэргэжил аргагүйн зөвлөмж өгсөн.

Төрийн болон хувийн хэвшлийн нийт 75 байгууллагад коронавирүст халдварын эсрэг дархлаа сэргээх нэмэлт 3, 4 дүгээр тунгийн талаар зөвлөмж хүргүүлсэн.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал

2022 оны 1 сарын байдлаар Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн сан LMIS программд ажил идэвхтэй хайгч 1106 иргэн бүртгэлтэй байгаагаас 526 эмэгтэй. Шинэ ажлын байр 26, үүнээс байнгын ажлын байр 26 байна. Ажил олгогч байгууллагуудаас ирүүлсэн ажлын байрны захиалга 26, зуучлал 26 байна. Тухайн сарын 14-ны байдлаар хайгчаар шинээр бүртгүүлсэн 71 иргэнийг LMIS программд бүртгэлээ. Ажил идэвхтэй хайгч иргэдийг боловсролын түвшингээр ангилвал: боловсролгүй- 13, бага- 41, суурь- 172, бүрэн дунд- 664, техникийн болон мэргэжлийн анхан шатны – 17, тусгай мэргэжлийн дунд- 24, Дипломын бакалаврын-175 иргэнийг тус тус бүртгэж мэдээллийн бааз үүсгэн ажилласан байна. Тухайн сард ажилгүйдлийн тэтгэмж авахаар ирсэн 17 иргэнийг LMIS програмд бүртгэн тодорхойлолт гарган өгч Нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлсэн.

Нийгмийн даатгалын сангийн анхан шатны бүртгэлийн маягтыг хөтлөх журам шинэчлэгдсэн бөгөөд энэ хүрээнд ажилгүйдэл болон жирэмсэн амаржсан, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны эмнэлгийн хуудсыг 2021 оны 01 сарын 01-ээс эхлэн цахим хэлбэрт шилжүүлэн ажиллаж байна.

2022 оны 01 дүгээр сард 15400 орчим тэтгэвэр, тэтгэмж авагчдад 5.5 тэрбум төгрөгийг хугацаанд нь шуурхай олгоод байна.

Малчны нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэврийн хувийн хэрэгт бүрдүүлж өгсөн материал, ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийн хүрээнд бүрдүүлж жил авсан материал зэргийг үндэслэн дотооддоо хяналт шалгалтыг зохион байгуулж дууслаа.

Гэр бүл, хүүхэд, залуучууд

Хүүхдийн асуудлаар үүрэг хүлээгчдэд хүүхдийн салбарт хэрэгжиж буй хууль тогтоомжийг сурталчлах, мэдлэгийг нэмэгдүүлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Эрдэнэбулган сумын 3 цэцэрлэгийн 80 орчим багш, албан хаагчдад хүүхдийн эрхийн талаар сургалт мэдээлэл өгч, хүүхдийн төлөө үүрэг хүлээгчдийн хариуцлагыг нэмэгдүүлэхэд анхаарч ажилласан.

Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн асуудлаар гаргасан 4 өргөдлийг хуулийн хугацаанд судалж дүгнэлт гаргаж, хүргүүлсэн.

Эрдэнэбулган сумын 4 дүгээр сургуулийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, гарсан зөрчил дутагдлыг арилгууллаа. Хүүхдийн тусламж 108 утаснаас шилжиж ирсэн дуудлага мэдээллүүдийг харъяаллын дагуу шилжүүлж, мөн иргэдээс ирүүлсэн 2 өргөдлийн дагуу холбогдох байгууллагад судлан шийдвэрлүүлэх зөвлөмж хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд

Мал аж ахуй

Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдаанаар Архангай аймгаас “Улсын аварга малчин” 5, “Улсын аварга саальчин” 1, “Улсын аварга фермер” 1 малчин тус тус шалгарлаа.

2021 оны жилийн эцсийн мал тоологын урьдчилсан дүнгээр тэмээ 1.6 мянган толгой, адуу 416.3 мянган толгой, үхэр 722.2 мянган толгой, хонь 2935.1 мянган толгой, ямаа 1486.9 мянган толгой, нийт 5562.2 мянган толгой мал тоолуулж өмнөх оноос 162.3 мянган толгой буюу 2.9 хувиар малын тоо толгой өссөн байна.

Аймгийн хэмжээнд 5562.2 мянган толгой мал өвөлжиж байгаагаас улсын тусгай хамгаалалттай бүс нутагт Чулуут Булган, Цэнхэр сумдын 246 өрхийн 94.1 мянган толгой мал өвөлжиж байна.

2022 оны 1 дүгээр сарын 26-ны байдлаар сумдын нөөцөд 1470 тн өвс, ногоон тэжээл, 511 тн гар тэжээл, аймгийн аюулгүй нөөцөд 100 тн өвс, 341.6 тн ногоон тэжээл, 55.8 тн гар тэжээлийн нөөц байна.

2021 оны 01 дүгээр сарын байдлаар бод 175, бог 369 толгой, нийт 544 толгой мал зүй бусаар хорогдсон байна.

Мал эмнэлгийн лабораторит давхардсан тоогоор 5 сумын /Цэнхэр, Жаргалант, Хашаат/ 4 эмгэгт дээж буюу 11 эмгэгт материалд стандарт арга зүйн дагуу нян судлалын шинжилгээг хийж гүйцэтгэхэд Жаргалант суманд Дотрын халдварт хордлого, Цэнхэр суманд Галзуу өвчин тодорхойлогдов. Холбогдох арга хэмжээг авч ажиллах тухай тухайн сумдад мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч ажиллаа. Ариун цэвэр магадлан шинжилгээг Эрдэнэбулган сумын “Сочу транс” тахианы аж ахуйн нэгжээс ирсэн 10 өндөгний дээжийг стандарт арга зүйн дагуу шинжлэхэд урвалын дүн сөрөг гарлаа. Хашаат сумаас ирсэн шүлхий өвчний эмгэгт дээжийг заавар арга зүйн дагуу УМЭАЦТЛ-т хүргүүлэх ажлыг зохион байгуулан хийхэд шинжилгээний үр дүн баталгаажив.

Малын гоц халдварт шүлхий өвчин гарсан 14 сумаас өдөр бүр мэдээ авч нэгтгэн Мал эмнэлгийн ерөнхий газар, аймгийн онцгой комиссын шуурхай штаб, онцгой байдлын газар тогтмол явуулж байна.

Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд

Байгаль орчин

Аймгийн ЗДТГ, Булган сумын ЗДТГ, сум дундын Ойн анги, Лондонгийн амьтан судлалын нийгэмлэг, Булган сумын нөхөрлөлүүдийн холбоо ТББ-тай хамтран Баянбулаг багийн Олон нүүр, Тамир багийн Жаргалант гэх газрын ойн түймэрт нэрвэгдэж шатсан талбайд ойн цэвэрлэгээний ажлыг байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн гишүүдээр гүйцэтгүүлж байна. Энэхүү ажлын онцлог нь ойн түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн, хүчтэй салхи, их цасанд өртөн амьдрах

чадваргүй болж үхжиж унасан хуурай мод, гишүү, мөчир, мод бэлтгэлийн талбайн үлдэгдэлийг цэвэрлэх замаар байгалийн сэргэн ургалтыг дэмжих, ойг хамгаалах, төлөв байдлыг сайжруулахад чиглэх юм.

Ойн цэвэрлэгээний ажлаар бэлтгэсэн түлээний модны ойн нөөц ашигласны төлбөрийг 80 хувиар хөнгөлж, байгаль хамгаалагчид мод бэлтгэх, тээвэрлэх үйл ажиллагаанд газар дээр хяналт тавьж ажиллаж байна.

Нөхөрлөлийн гишүүд ойгоос бэлтгэсэн түлээний модыг аймгийн төвийн иргэдэд хөнгөлөлттэй үнээр 2022 оны 01 дүгээр сарын 23-аас 25-ны өдрүүдэд худалдан борлуулна.

"Архангай аймгийн зочлох үйлчилгээний цахим шилжилт" сургалтыг 1 сарын 12 - ны өдөр цахимаар зохион байгуулж, Архангай аймагт жуулчны бааз, зочид буудал, гэр буудал, дэн буудлын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 26 аж ахуйн нэгж, байгууллагын захирал, менежер, зохион байгуулагч, нягтлан бодогчдын төлөөлөл хамрагдлаа.

Энэхүү сургалтаар онлайн борлуулалт, онлайн аялал жуулчлалын талаар мэдлэг мэдээлэл өгөхөөс гадна MyHotel платформд Амралтын газар, зочид буудал удирдлагын систем, iHotel сайтад Зочид буудал, амралтын газар борлуулалтын вэб сайтад аж ахуй нэгжийн бүртгэл үүсгэх зэргийг практикаар гүйцэтгэлээ.

Аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/43 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсэг 01 дүгээр сарын 19-ний өдөр "Өгий нуурын аялал жуулчлал" хэлэлцүүлэг уулзалтыг зохион байгууллаа.

Барилга, дэд бүтэц, газар

2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр хүүхдийн "Тамир" зусланг олон улсын хүүхдийн зуслан болгох хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөл боловсруулах цахим хэлэлцүүлэгт "Гоби трэвэл" ХХК, аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын удирдлагууд оролцлоо. Хэлэлцүүлгийн үеэр ажлын явц болон ерөнхий төлөвлөгөөг танилцууллаа. Зураг төсөл боловсруулах ажлын явц 40 хувьтай явагдаж байна.

Зургийн даалгавар боловсруулах ажлын хүрээнд шинээр 4 гэрээ байгуулсан. Үүнд: Ихтамир сумын "Сумын төвийн шинэчлэл", Ихтамир сумын Хүүхдийн цэцэрлэгийн засвар, барилгын өргөтгөл, Жаргалант сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажил.

Архангай аймагт 2022 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийт 171 тэрбум 866.2 сая төгрөгийн өртөг бүхий 69 төсөл арга хэмжээний захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байгаа бөгөөд 2022 оны 1 дүгээр сард дараах барилгуудад үе шатны хяналт хийлээ. Үүнд:

- ✓ Жаргалант сумын Соёлын төвийн барилгын ажил-80%
- ✓ Хашаат сумын Сургуулийн өргөтгөлийн барилгын ажил-85%
- ✓ Чулуут сумын 320 суудалтай сургуулийн барилгын ажил-90%.
- ✓ Төвшрүүлэх сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажил-30%
- ✓ 300 ортой аймгийн Нэгдсэн эмнэлгийн барилга угсралтын ажил-35%
- ✓ Чулуут сумын Соёлын төвийн барилга-90%
- ✓

Хүнс, үйлдвэрлэл үйлчилгээ

1 дүгээр сарын 19-ний өдөр, Хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан хуулийн үр дүн, ач холбогдлыг таниулах, хоршоодын гишүүдийг чадавхижуулах сургалт зохион байгууллаа.

Энэхүү сургалтад 19 сумын Засаг дарга, Хөдөө аж ахуйн мэргэжилтнүүд, хоршоодын төлөөлөл оролцож Хоршооны хуулийн шинэчилсэн найруулга, Сум хөгжүүлэх санг Хоршоо хөгжүүлэх сан болгосон журмын талаар мэдээлэл авч байна. Архангай аймгийн хэмжээнд 247 хоршоо бүртгэлтэй байдгаас 157 хоршоо үйл ажиллагаа явуулж байна. Хоршоодыг үйл ажиллагаагаар нь ангилбал 114 нь хөдөө аж ахуй, ес нь хадгаламж зээл, 34 нь худалдаа, үйлдвэрлэлийн чиглэлээр ажилладаг статистик гарчээ. 2021 оны жилийн эцсийн тооллогоор 157 хоршоонд 600 гаруй иргэн ажиллаж 900 орчим нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нийлүүлж байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

-----oOo-----